

Төсөл

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны ... дүгээр сарын ...-ны
өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Зарим албан тушаалтны цалингийн хэмжээг
тогтоох тухай

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 57 дугаар зүйлийн
57.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тухай хуулийн 11.1.11, 11.2-т заасан улс төрийн албан тушаал, 13.1.6-д заасан шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэнг дараахь байдлаар төрийн албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтай адилтгаж, албан тушаалын сарын үндсэн цалинг эдгээр албан тушаалын сарын үндсэн цалинтай адилтган тогтоосугай.

№	Улс төрийн болон төрийн тусгай албан тушаал	Адилтгах албан тушаал
1	Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны дарга	Улсын Их Хурлын Тамгын газрын Нарийн бичгийн дарга
2	Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны зөвлөх	Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх, ахлах референт
3	Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ахлах референт	Улсын Их Хурлын Тамгын газрын референт
4	Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны референт	Сум, дүүргийн Засаг дарга
5	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	Цагдаагийн байгууллагын офицер, шинжээч, мэргэжилтэн
6	Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн	Цагдаагийн байгууллагын офицер, ахлагч

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлд адилтгах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 63 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 43 дугаар тогтоолыг хүчингүй болгохыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ